ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СТАНДАРТ, ЭРХЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХИ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Г. Алтан-Оч (Ph.D), С. Дорждагва, Ө. Мөнхтунгалаг, Б. Мөнхцэцэг

АГУУЛГА

1. ОРГАНИК ХҮНС
2. ОРГАНИК ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ЗАРИМ ТОО БАРИМТ
3. ОЛОН УЛСЫН ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭГДСЭН ХӨДӨЛГӨӨН БА ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРЧМУУД
4. АНУ -Д ҮНДЭСНИЙ ОРГАНИК ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТУРШЛАГА

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

* * *

НЭГ. ОРГАНИК ХҮНС

Үйлдвэржилт хөгжсөнөөр хүнсний хангамжийг шийдвэрлэхийн тулд хүнсэнд олон төрлийн боловсруулалт хийх, нэмэлт бодисоор баяжуулах байдал нилээдгүй түгээмэл болсон байдаг. Энэ нь хэдийгээр хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, шимт байдлыг сайжруулах гэх мэт олон ач холбогдолтой ч сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд хүнсийг органик байдлаар хэрэглэх хандлага улам нэмэгдэх болжээ. Өөрөөр хэлбэл, уламжлалт хөдөө аж ахуйн аргаар боловсруулсан, бий болгосон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн буюу бий болгох явцад ашиг шимийг нь нэмэгдүүлэх хандлагатай байлаа. Харин сүүлийн үед уламжлалт хөдөө аж ахуйгаас органик хөдөө аж ахуй руу шилжих шилжилт явагдаж байна.

Өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ нь органик хүнсийг үйлдвэрлэх, борлуулах зах зээлд манай орны хувьд багагүй боломж байгааг харуулж олон улсын стандартуудыг чиг баримжаагаа болгон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж чадвал ихээхэн боломжийг бий болгож өгч байгаа юм.

ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙ гэдэг нь хүний эрүүл мэнд, экосистемийн хэвийн байдал, хөрсний үржил шимийг алдагдуулахгүй эрүүл байлган, үйлдвэрлэл явуулахыг илэрхийлсэн цогц систем юм. Энэхүү систем нь тухайн байгалийн болон бусад нөөцийг ашиглахдаа орон нутгийн нөхцөл байдалд дасан зохицсон биологийн төрөл зүйлийн зохицол, байгаль экологийн өөрийн хэвийн үйл явцыг хангахад суурьладаг ба уламжлалт арга барилыг шинжлэх ухаан технологийн дэвшлийг хослуулснаар, үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүртэл бүхий л шат дамжлагад, хүн болон байгалийн харилцан шүтэлцээг хангаж, энэхүү харилцаанд оролцогч талуудын амьдралын чанарыг хамгийн сайн байлгах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Органик хөдөө аж ахуй нь эдийн засгийн өсөлт, хүрээлэн буй орчны хамгаалал, хүнсний чанар, аюулгүй байдлын асуудал, цаг уурын өөрчлөлт, нийгмийн шударга байдал гэсэн олон ойлголтуудыг хамарсан сайн нөлөөг үзүүлдэг.

Органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого нь үйлдвэрлэгч хэрэглэгчийн эрх ашгийг аль альныг нь хамгаалан экологи болон нийгмийн дадал туршлагын сайн хэсгийг дэмжих ёстой ба улс орон бүрийн хувьд органик хөдөө аж ахуйг дэмжсэн бодлого болон дэмжих хүчин зүйл байгаа, байхгүй гэдгээрээ өөр хоорондоо ялгаатай байдаг. Органик хөдөө аж

ахуйн үндсэн стандартууд нь тогтвортой хөдөө аж ахуйг бий болгоход чиглэгдсэн байдаг ба дэлхийн улс орон бүр өөр өөрийн гэсэн онцлогтой бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг органик шинж чанартай болгосноор гарц нэмэгдэж эрчим хүч, газар, хүн хүчийг хэмнэх боломжийг бүрдүүлж байна гэж үздэг. Үр ашиг гарч байгаа жишээ: Өмнөд Бразилын улаан буудайн тариаланг органикаар эрхэлж азот шингээгч хүнсний ногоо тариалсны үр дүнд химийн бордоо хэрэглэх шаардлагагүй болсон ба Мексикийн коффены тариалан эрхлэгчдийн хувьд бүрэн органик аргаар тариалсны үр дүнд буурцагны жин 50% иар нэмэгдсэн байна гэсэн судалгаанууд байна[92].

Хотжих, үйлдвэржих процесс нэмэгдсэн, цөлжилт гэх мэт хүчин зүйлсээс шалтгаалж хүний хэрэгцээнд хэрэглэх ургамлыг ургуулахад шаардагдах газар хомсдож байгаа, сул чөлөөтэй газар нутгийн ихэнх хувийг мал аж ахуйн зориулалтаар ашиглаж, малын тэжээл тариалж буй тариалангийн талбай, энэхүү талбайг гаргахын тулд устгаж буй ойн асуудалтай нягт уялдаж байна.

Үүний нэгэн жишээ: Энэтхэг улс хүн амын өсөлтөө хязгаарлаж чадаагүйгээс өнөөдөр 1,2 тэрбумыг даваад байна. Үүний улмаас хотжих процесс маш хурдацтай өсч тус улсын хөдөө аж ахуй эрхлэх газрын хэмжээ эрс багасжээ. Нөгөө талаар газар их үнэд орж байгаа учраас хөдөө аж ахуй эрхлэгчид газраасаа зарах хандлага нэмэгдэж, тухайн зарагдсан газар нь хөдөө аж ахуйд бус барилга, үйлдвэрийн зориулалтаар ашиглагдаж байгаа нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг бууруулах үндэс болжээ.

Өөр нэгэн жишээ: Европын орнуудын фермерийн аж ахуй өндөр хөгжсөн улсуудад малаас гарах ашиг шимийг нэмэхэд зориулж малын тэжээл, малд зориулсан нэмэлт хүнсийг ихээр тариалсанаар шууд хүний хэрэгцээнд зориулсан хүнсний тариалалтын хэмжээ нэмэгдэж чадахгүйд хүрэх хандлага үүсгэжээ. Эндээс органик хүнс бэлтгэх хэрэгцээ, өсөн нэмэх боломж нь газар тариалан, мал аж ахуйн салбарт бас хоорондын зөрчил эдгээр орнуудад бий болж байгааг харж болох юм.

Органик хөдөө аж ахуй эрхлэх боломж нь үйлдвэржсэн хөгжингүй орнуудад тийм амаргүй нөхцөл байдалтай байдгийн гол шалтгаан нь дэлхий нийтийн хүн амын хэт их хэрэглээ буюу өдөр тутмын хүнсний хэрэгцээний орц найрлага хэт замбараагүй болсон түүнийг хангахын тулд эрхэлж буй үйлдвэрлэлийн хэмжээ төдий хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой.

Дэлхийн уушиг болсон олон ширэнгэн ой, мал ахуйг өргөжихийн хэрээр устаж, агаараас хорт бодисыг шүүж цэвэрлэх, дэлхийн агаарын чадамж, экологийн үйл явц доголдож агаарт байх хорт бодисын хэмжээ хэт ихсэн, энэ нь эргээд органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хязгаарлаж байна. Мөн хүний хэрэгцээнд зориулан органик байдлаар үйлдвэрлэх боломжтой бүх төрлийн хүнсний ашигт ургамлуудыг тарьж ургуулах зардлаас мал аж ахуйг тэжээх зардал хэдийн хол давжээ.

Энэ бүхэн бол дэлхий нийт органик хөдөө аж ахуй тэр дундаа органик газар тариалангийн салбарыг нэн даруй анхааралдаа авч дорвитой арга хэмжээ авах цаг нь болсон гэдгийг харуулж байна.

* * *

[92] http://www.ifoam.org/growing_organic/1_arguments_for_oa/arguments_main_page.html

ХОЁР. ОРГАНИК ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ЗАРИМ ТОО БАРИМТ

Дэлхий нийтэд органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллаж буй нийт 1.4 сая үйлдвэрлэгч байдаг ба 2009 оны байдлаар тэдний үйлдвэрлэлдээ ашиглаж буй нийт 35,0 сая га талбайг албан ёсоор органик тариалан гэж баталгаажуулсан байна. Органик тариалан эрхлэгч, дэлхий нийтэд тэргүүлэгч орнуудыг дурьдвал:


Indicator		Leading countries 2009
Countries with data on certified organic agriculture 20091	2009: 160 countries (2008: 154; 2000: 86)	
Organic agricultural land 2009	37.2 million hectares (2008: 35.2, 1999: 11)	Australia (12 million ha), Argentina (4.4 million ha), US (1.9 million ha)
Number of countries with more than five percent organic agricultural land 2009	24 countries (2008: 22); More than ten percent: 7 countries (2008: 6 countries)	Falkland Islands (Malvinas) (35.7 %), Liechtenstein (26.9 %), Austria (18.5 %)
Further, non-agricultural organic areas 2009	41.9 million hectares (2008: 31 million)	Finland (7.8 million ha), Brazil (6.2 million ha); Cameroon (6 million ha).
Producers 2009	1.8 million producers (2008: 1.4 million)	India (677’257), Uganda (187’893), Mexico (128’826)
Organic market size 2009	54.9 billion US dollars or 40 billion euro (2008: 50.9 billion US dollars; 1999: 15.2 billion)	US (17.8 billion euro), Germany (5.8 billion euro), France (3 billion euro)
Number of countries with organic regulations 2010	74 countries (2008: 73 countries)	
Organic certifiers 2010	523 certifiers (2008: 489)	Japan, USA, South Korea
Number of IFOAM affiliates 2011	1.1.2011: 757 affiliates (2008: 734 affiliates 2000: 606 affiliates)	Germany: 98 affiliates; United States: 45 affiliates; India: 44 affiliates

Source: FiBL and IFOAM; for total global market: Organic Monitor; for certifiers: Organic Standard/Grolink.


Organic agricultural land (including in-conversion areas) and regional shares of the global organic agricultural land 2009[93]

Region	Organic agricultural land (hectares)	Regions' share of global agricultural land
Africa	1'026'632	2.8
Asia	3'581'918	9.6
Europe	9'259'934	24.9
Latin America	8'558'910	23.0
Oceania	12'152'108	32.6
Northern America	2'652'624	7.1
Total	37'232'127	100.0

Дэлхийд тэргүүлэгч органик тариалан эрхлэгчид/тариалан эрхлэлтийн газар нутгийн хэмжээгээр



Газар нутгийн бүсчлэлээр ангилсан байдлаарх органик хөдөө аж ахуй эрхлэлтийн байдал дэлхий нийтэд:



[93] The World of Organic Agriculture Statistics and Emerging Trends 2011. FiBL and IFOAM

Дэлхийн хэмжээнд ашиглах чөлөөтэй, боломжтой гэж үзсэн нийт газар нутгийн 52% ийг хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа үлдсэн 48% ийг одоо болтол ашиглаагүй хэвээр байна. Эдгээр ашиглагдаагүй газар нутагт ой хөвч, усан сангуудын эргэн тойрон, бэлчээр болон зэрлэг байгалийн зүй тогтол багтаж байгаа. Ашиглагдаж байгаа газар нутаг нь тариалангийн газар, бусад хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа гэж хуваагдаж байна. Дэлхийн хэмжээнд нийт 154 орон органик газар тариалан эрхэлж байгаа гэсэн мэдээ байдаг ба эдгээр нь газар нутгийн хэмжээгээр харилцан адилгүй.

Органикаар тариалж буй нийт ургамлын 45% нь эрдэнэшиш, 34% нь буудай болон түүнтэй төстэй ургамлууд, 5% өндөр уурагт ургамлууд, 5% нь хүнсний ногоо, 11 % нь жимс жимсгэнэ, самар, кофе, цайны ургамал, хөвөн, болон ил талбайн хүлэмжийн бүх навчит, үрт ургамлууд орж байна. Эдгээр нийт тариалж буй эрдэнэшиш болон буудай, буурцагт ургамлуудын 80% ийг хүний биш малын тэжээлийн зориулалтаар ашиглаж байна[94].

Ази тивийн хувьд органик байдлаар ашиглаж байгаа нийт газар нутгийн 56% нь Хятад, 31% нь Энэтхэг, 3% Казакстан, 2% Индонез, 8% нь бусад орнуудад ноогдож байна. Мөн Ази тивийн хувьд Япон органик бүтээгдэхүүний хамгийн их эрэлттэй зах зээл бөгөөд тогтвортой өсөлттэй үнийн өндөр мэдрэмжтэй зах зээл юм.

Органик бүтээгдэхүүний хамгийн их эрэлт хэрэгцээтэй газар буюу хамгийн их борлуулалт хийгддэг газарт Европ тивд Герман, Франц, Англи, Итали орнууд ордог ба нэг хүнд ноогдох органик бүтээгдэхүүний хэрэглээгээр Дани, Швецарь, Австри, Герман, Швед улсууд тэргүүлдэг байна. Европын хувьд нэг хүнд ноогдох органик бүтээгдэхүүний борлуулалт 1 жилд 28 евро, буюу жилийн нийт борлуулалт 18 тэрбум евро байдаг байна. Мөн Европ тивийн 38 орон нь органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар бүрэн хэмжээний цогц дагаж мөрдөх журам, албан ёсны хууль тогтоомжтой байдаг.

2011 оноос эхлэн органик бүтээгдэхүүний зах зээл 4%-8% болон түүнээс дээш жилийн өсөлттэй байхаар харагдаж байгаа ба энэхүү өсөлтийг даган хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчдийн сэтгэл зүйд дараах өөрчлөлтүүд гарч эхэлжээ.

Хэрэглэгчдийн хэрэглээний өөрчлөлтийн хандлага:

- Байгаль орчиндоо анхаарал хандуулах нь нэмэгдэж байна
- Химийн элемент ороогүй бүтээгдэхүүнийг илүүд үзэх болсон
- Бүтээгдэхүүний гарал үүслийг анхаарч шалгадаг болсон
- Оршин сууж байгаа орон нутгаасаа шинэ бүтээгдэхүүн авах сонирхолтой болсон
- Хаяг, шошго, баталгаанд анхаарлаа хандуулдаг болсон
- Чанарыг нэг хэвийн байнга найдвартай байхыг хүсдэг болсон

* * *

ГУРАВ. ОЛОН УЛСЫН ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭГДСЭН ХӨДӨЛГӨӨН БА ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРЧМУУД

IFOAM[95]-Олон Улсын Органик Хөдөө Аж Ахуйн Нэгдсэн Хөдөлгөөн нь дэлхийн 750 гишүүн байгууллага, 116 орныг өөртөө нэгтгэсэн органик хөдөө аж ахуйн нэгдсэн томоохон хөдөлгөөн бөгөөд дэлхий дахинд тасралтгүй өсөн нэмэгдэж буй органик бүтээгдэхүүний

[94] www.organicmongol.mn

[95] http://www.ams.usda.gov/AMSv1.0/nop

эрэлт хэрэгцээг хангахын тулд 2008 оны байдлаар дэлхий нийтэд 26 сая га, 2010 оны байдлаар 35 сая га газарт органик тариалан эрхэлж байна гэсэн мэдээг гаргажээ. Тухайн бүтээгдэхүүний органик мөн эсэхийг батлах дэлхий нийтийн баталгааны систем байдаг ба энэ нь зах зээлийн тодорхойлолт, нотлох баримт, стандартуудаас бүтсэн бүгдэд ойлголжтой систем юм. Хэрэглэгчдийг тухайн бүтээгдэхүүнийг органик мөн эсэхэд итгэх итгэлийг олж авахын тулд үйлдвэрлэгчдийн дагаж мөрдөх бүхий л хэм хэмжээг органик бүтээгдэхүүний стандартад тодорхойлж өгсөн байдаг.

Олон Улсын Органик Хөдөө Аж Ахуйн Хөдөлгөөн нь органик бүтээгдэхүүн болон түүний үйлдвэрлэлийн явцад тавигдах нормыг гаргасан байдаг. Одоо мөрдөгдөж байгаа стандартыг 2005 онд баталсан. Энэ стандартыг шинэчлэхээр төсөл боловсруулан хэлэлцүүлгийн шатанд явж байна. Энэ төслийг хэлэлцүүлгийн явцад гарсан саналын хамт мөн хавсралтад орууллаа /4-р хавсралтыг үз/.

Тус стандарт, нормд баримтлах үндсэн 4 зарчмыг тодорхойлсон байна. Органик хөдөө аж ахуйн зарчмууд нь органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх үндэс бөгөөд дэлхийн хэмжээнд хөдөө аж ахуй эрхлэлтийг сайжруулах замаар органик хөдөө аж ахуйг энхийн зорилгоор бий болгох бүхий л боломжийг тусгасан байдаг. Хөдөө аж ахуй нь хүний өдөр тутмын амьдралын хэрэгцээт хүнсийг бий болгож байдгаараа хүн төрөлхтний амьдрал үйл ажиллагааны үндсэн хэсэг болдог.

Түүх, соёл, нийгмийн үнэт зүйлүүд нь хөдөө аж ахуйд өөрийн тусгалаа олсон байдаг ба органик хөдөө аж ахуйн зарчмуудыг хүмүүс янз бүрийн арга хэрэглэн газар усыг тордох замаар амьтан ургамлыг өөрчлөн хүнсний бүтээгдэхүүн болон бусад эд зүйлсийг үйлдвэрлэх, дахин боловсруулах, хуваарилах, түгээх зорилгоор өргөнөөр хэрэглэх болно. Эдгээрт хүн төрөлхтөн байгалийн бүхий л төрх байдалтай /ландшафт/ харилцан үйлчлэх явцдаа түүнийг үеийн үед ирээдүй хойчдоо үлдээх, бие биетэйгээ харилцан холбоотой байгаль хамгаалах аргууд хамаарна.

Органик хөдөө аж ахуйн зарчмууд нь органик хөдөлгөөнүүдийн бүх хэлбэрийг хөхиүлэн дэмжихэд чиглэдгээс гадна энэ хөдөлгөөний стандарт, хөтөлбөр, хөгжлийн үндсийг зохицуулж, эдгээрийг дэлхий даяар хэрэглэх бүхий л бололцоог боловсронгуй болгож байдаг. Органик хөдөө аж ахуй нь

- Эрүүл мэндийн
- Экологийн
- Шударга ёсны
- Хариуцлагатай харилцан ашигтай байх

зарчмуудад үндэслэгддэг. Энэ зарчмууд нь нэгдмэл зорилгоор ашиглагдана.

1. Эрүүл ахуйн зарчим

Энэ зарчим нь эрүүл хөрсөнд, эрүүл ургамал ургаж энэ нь эрүүл хүн, амьтныг бий болоход нөлөөлөх буюу өөрөөр хэлбэл нийгэм болон амьд бие бүрийн эрүүл мэнд нь экосистемийн эрүүл мэндээс салангид тусдаа оршихгүй гэдгийг харуулна.
\
Эрүүл байна гэдэг нь, амьд биеийн нэгдмэл цул чанар бөгөөд энгийн өвчнөөс биеэ хамгаалах төдийгүй оюун санаа бие бялдраа нийгэм, экологийн сайн сайхны төлөө эрүүл байлгах явдал юм. Органик хөдөө аж ахуйн үүрэг нь хувийн аж ахуй эрхлэгчид бүтээгдэхүүнээ боловсруулахаас эхлээд, үйлдвэрлэх, түгээх, хэрэглэх бүх шатандаа энгийн хөрснөөс эхлээд хүн төрөлхтөн хүртлэх бүх амьд организм болон экосистемийн эрүүл мэндийг дэмжиж түүнийг сайжруулахад анхаарах ёстой. Тухайлбал, органик хөдөө аж ахуй нь эрүүл, амар мэнд оршин тогтнохын тулд аливаа өвчнөөс урьдчилан

сэргийлэхэд тус нэмэр болохуйц дээд зэргийн чанартай хүнсний бүтээгдхүүн үйлдвэрлэх ёстойг ойлгох явдал юм.

Энэ зарчим ёсоор эрүүл мэндэд таагүй нөлөө үзүүлж болох хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, амьтанд зориулсан мал эмнэлгийн бэлдмэл, хорхой шавьж устгах химийн хорт бодис / пестицид/, ургамлын бордоо ашиглахаас зайлсхийх ёстой.

2. Экологийн зарчим

Органик хөдөө аж ахуйг эрхлэхдээ амьдарч байгаа хүрээлэн буй орчинд нь түүнтэй салшгүй холбоотойгоор зэрэгцэн аливаа үйл ажиллагааг явуулах зарчимд үндэслэгдэх ёстой. Энэ зарчим нь амьд экосистемийн орчинд нь органик хөдөө аж ахуйг эрчимжүүлэх явдал бөгөөд үйлдвэрлэл болон дахин боловсруулалтыг байгалийн нөхцөлд нь явуулахад үндэслэгдэнэ. Жишээ нь, ургамлыг амьд хөрсөнд, амьтдыг цэвэр байгалийн орчинд, загас болон далайн амьтдыг усан орчинд нь өсгөх зэргийг дурьдаж болно. Энэ зарчмаар, ургац авах зорилгоор атар газар эзэмших, онгон байгалийн нөхцөлд бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх нь байгалийн эргэлт тэнцвэржилтэнд зохистой нөлөө үзүүлдэг гэж үздэг.

Органик хөдөө аж ахуйг удирдахдаа хүрээлэн байгаа орчин, соёл, хүрээлэлд нь дасан зохицох ёстой. Органик хөдөө аж ахуй нь амьд организмын генетикийн олон төрөл зүйл амьтдыг өсгөн орших газар нутаг бий болгох замаар экологийн тэнцвэржилтэнд хүрэх ёстой. Үйлдвэрлэгчид, дахин боловсруулагчид, худалдаачид, органик бүтээгдхүүнийг хэрэглэгчид нь хүрээлэн байгаа орчин, орчны уур амьсгал, ландшафт, биологийн олон төрөл зүйл амьтан, агаар, усыг хамгаалах ёстой.

3. Шударга ёсны зарчим

Органик хөдөө аж ахуй нь хүрээлэн байгаа орчин бүхий л амьд биеийн оролцоотой шударга ёсыг бий болгох харилцааг бүтээх ёстой. Шударга ёс гэдэг нь аж ахуй хоорондын харьцаа болон хүмүүс хоорондын харьцаа, бүх амьтдын өөр хоорондын харьцаанд бодитой, хүндэтгэлтэй, тэнцвэртэй хандах байдлаар тодорхойлогдоно. Энэ зарчим нь органик хөдөө аж ахуйд ажиллагсад, аж ахуй эрхлэгчид, дахин боловсруулагчид, түгээн дэлгэрүүлэгчид, худалдаачид, хэрэглэгчид зэрэг оролцогч талуудаас бүхий л түвшинд шударга ёсыг батлан харуулах, энэрэнгүй байх зарчим баримтлахыг шаардана.

Энэ зарчим ёсоор, органик хөдөө аж ахуй нь ядуурлыг бууруулахад субьект бүрийг хамруулж хүрэлцэхүйц хэмжээний сайн чанарын хүнсний бүтээгдхүүнийг үйлдвэрлэхэд эх орны үйлдвэрлэлийг чиглүүлэх ёстой. Мөн амьтан хүртэл өөрийн физиологи, эрүүл мэнд, байгалийн зан үйлдээ тохирсон амьдралын орчин нөхцлөөр хангагдах ёстой гэж заасан байна. Ирээдүй хойч үеийнхээ ашиг сонирхолд нийцсэн экологи нийгмийн шударга ёсны үзэл санааг тооцож байгалийн нөөц баялгаа үйлдвэрлэлд ашиглана. Шударга ёс нь экологи нийгмийн бодит сүйрлийг харгалзан тооцсон нээлттэй тэгш эрхт худалдаа үйлдвэрлэлийн системийг шаардаж байна.

4. Харилцан хариуцлагатай байх зарчим

Органик хөдөө аж ахуйн удирдагчид нь хүрээлэн байгаа орчин болон одоогийн ба ирээдүй хойч үеийнхний сайн сайхан аж байдал, эрүүл мэндийг хамгаалахын тулд хариуцлагатай, урьдаас сэрэмжилсэн чанарыг тээж явах ёстой. Органик хөдөө аж ахуй нь гадаад дотоод нөхцөл ба хэрэгцээг нөхцөлдүүлсэн амьд хөдөлгөөнт систем юм. Хэн ч органик хөдөө аж ахуйн аргыг ашиглаж үйлдвэрлэлээ нэмэгдүүлж үр ашгаа дээшлүүлж болох боловч бусдын эрүүл мэнд, сайн сайхан, аж байдалд эрсдэл учруулах ёсгүй. Иймээс, хөдөө аж ахуй эрхлэгчид шинээр бий болж буй аргыг тогтмол хянаж шинэ технологийг байнга үнэлж байх ёстой.

Хөдөө аж ахуй эрхлэх талаар хангалттай ойлголтгүй тохиолдолд зохих ёсны арга хэмжээнүүдийг урьдчилан авах ёстой. Харилцан хариуцлагатай байх зарчим нь органик хөдөө аж ахуйд хэрэглэгдэх дэвшилтэт технологийн хөгжлийг бэхжүүлэх аргыг нэвтрүүлэхээс гадна эрсдлээс урьдчилан сэргийлэх ёстой.

Энэ тохиолдолд зөвхөн салангид шинжлэх ухааны мэдлэг хангалттай бус, дадлага туршлага, хуримтлагдсан уламжлалт ухаан, орчин үеийн мэдлэг нь оновчтой шийдвэр шалгарсан хэрэглээг бий болгохыг үргэлж сануулж байдаг. Органик хөдөө аж ахуй нь зохистой технологи ашиглах замаар эрсдлийг арилгах ёстой. Гарах үр дүн нь тодорхой бус генийн инженерчлэл мэтийн өндөр технологиос татгалзах чадвартай байх ёстой.

ДӨРӨВ. АНУ-Д ҮНДЭСНИЙ ОРГАНИК ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТУРШЛАГА

АНУ-ын органик хүнсний үйлдвэрлэл нь /Organic Foods Production Act of 1990/ органик хүнсний бүтээгдэхүүний тухай хуулиар органик хүнсний бүтээгдэхүүний үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна[96]. АНУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас /United States Department Of Agriculture/ органик стандартын шаардлага хангасан мал аж ахуйн болон газар тариалангийн органик бүтээгдэхүүнийг баталгаажуулдаг байна. Тус яам нь нийт 90 гаруй органик бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд органик бүтээгдэхүүний үйлдвэрлэх, боловсруулах, худалдаалах бүх шатанд хяналт тавьж ажиллахаас гадна эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөрчил гаргасан аж ахуйн нэгжүүдэд албадлагын арга хэмжээ ч авах эрхтэй байдаг байна.

Үндэсний органик хөтөлбөр /National Organic Programm/ нь органик бүтээгдэхүүнийг АНУ-д болон дэлхий нийтэд таниулах болон баталгаажуулах, хөдөө аж ахуйн маркетингийн үйлчилгээ үзүүлэх, хөгжиж байгаа орнуудад органик бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний стандарт тогтооход дэмжлэг үзүүлэх зорилго тавьж ажиллаж байна.
Хөтөлбөрийн үндсэн зорилго нь органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс таны ширээн дээр, органик шошго бол баталгаатай органик бүтээгдэхүүн гэдгийг хэрэглэгчдэд итгүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Органик бүтээгдэхүүний стандарт болон шинэчлэгдсэн стандартуудыг зохицуулах;
- Үндэсний хэмжээнд ашиглаж болох бодисуудын жагсаалт гаргаж зөвшөөрөл олгох;
- Баталгаажсан органик бүтээгдэхүүнүүдийг дахин баталгаажуулах;
- Органик бүтээгдэхүүнийг экспортлох болон импортлох бодлогын зохицуулалт;
- Хэрэглэгчдийн санал, гомдлын дагуу хянан шалгах;
- Холбооны зөвлөлийн хороо, үндэсний органик стандартын зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх;
- АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны албан хаагчид, хамтран ажиллаж буй байгууллагуудад сургалт зохион байгуулах.

Органик стандартын тухай

Органик стандартыг тогтоохдоо 3 ангилан авч үздэг.

[96] www.wikipedia.org

- Газар тариалангийн гаралтай органик бүтээгдэхүүний стандарт: АНУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас органик бүтээгдэхүүн гэж баталгаажуулахдаа цацрагийн бохирдолгүй, байгалийн гаралтай хөрс шороонд тарьсан, азотын бордоо болон хортон шавьжны эсрэг пестицид ашиглаагүй, генийн өөрчлөлтгүй байх;
- Мал аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүний стандарт: Мал аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ байгалийн гаралтай органик нэгдлүүдээр боловсруулсан хоол хүнсээр, ямар ч химийн найрлага хольц, технологийн боловсруулалт хийлгүйгээр үйлдвэрлэсэн байх;
- 95 хувиас багагүй хувийн органик бүтээгдэхүүний стандарт: Тус стандарт нь тухайн хүнсний бүтээгдэхүүний 95-аас багагүй хувь нь органик бүтээгдэхүүн байх үндсэн шаардлагуудыг тус тус тавьдаг байна.

Үндэсний органик хөтөлбөр нь эдгээр стандартуудыг таниулах, үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, худалдаалах, борлуулах, маркетингтэй холбоотой бүх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход үндсэн үйл ажиллагаа чиглүүлдэг байна.

* * *

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. Органик хөдөө аж ахуйн эрх зүйн зохицуулалттай орнуудын жагсаалт /2х./
2. Органик хөдөө аж ахуйн эрх зүйн зохицуулалт бий болгохоор ажиллаж байгаа орнуудын жагсаалт /1х./
3. Зарим улс орнуудын органик хөдөө аж ахуйн эрхзүйн баримт бичиг болон танилцуулгуудын файлын жагсаалт /2х., 26 холбоос/
4. Олон Улсын Органик Хөдөө Аж Ахуйн Нэгдсэн Хөдөлгөөн (IFOAM)-ий Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн стандарт, 2010 оны төсөл /англиар, 49х./
5. АНУ-ын Органик хүнсний үйлдвэрлэлийн тухай холбооны хууль /англиар, 12х./
6. АНУ-ын Үндэсний органик хөтөлбөр /англиар, 8х./
7. Швейцарийн Органик фермийн аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, маркетингийн стандарт (Bio Suisse), 2011 он /англиар, 58х./
8. Европын холбооны биш улсын үйлдвэрлэгчийн органик орлуулагчийн стандарт (IMO), 2010 он /англиар, 100х./

* * *

Хавсралт - 1.

Органик хөдөө аж ахуйн эрх зүйн зохицуулалттай орнуудын жагсаалт
List of countries with regulations on organic agriculture

Region	Country	Status
European Union (27)	Austria	Fully implemented
	Belgium	Fully implemented
	Bulgaria	Fully implemented
	Cyprus	Fully implemented
	Czech Republic	Fully implemented
	Denmark	Fully implemented
	Estonia	Fully implemented
	Finland	Fully implemented

	France	Fully implemented
	Germany	Fully implemented
	Greece	Fully implemented
	Hungary	Fully implemented
	Ireland	Fully implemented
	Italy	Fully implemented
	Latvia	Fully implemented
	Lithuania	Fully implemented
	Luxembourg	Fully implemented
	Malta	Fully implemented
	Poland	Fully implemented
	Portugal	Fully implemented
	Romania	Fully implemented
	Slovak Republic	Fully implemented
	Slovenia	Fully implemented
	Spain	Fully implemented
	Sweden	Fully implemented
	The Netherlands	Fully implemented
	United Kingdom	Fully implemented
Others Europe (10)	Albania	Not fully implemented
	Croatia	Fully implemented
	Iceland	Fully implemented
	Macedonia	Fully implemented
	Moldova	Fully implemented
	Montenegro	Fully implemented
	Norway	Fully implemented
	Serbia	Not fully implemented
	Switzerland	Fully implemented
	Turkey	Fully implemented
Asia and Pacific Region (11)	Australia	Only export regulations
	Bhutan	Not fully implemented
	China	Fully implemented
	India	Only export regulations
	Israel	Fully implemented
	Japan	Fully implemented
	New Zealand	Only export regulations
	Philippines	Not fully implemented
	South Korea	Fully implemented
	Taiwan	Fully implemented
	Thailand	Fully implemented
The Americas and Caribbean (14)	Argentina	Fully implemented
	Bolivia	Not fully implemented
	Brazil	Fully implemented
	Canada	Not fully implemented
	Chile	Fully implemented

	Costa Rica	National regulations not fully implemented
	Dominican Republic	Not fully implemented
	Ecuador	Fully implemented
	El Salvador	Not fully implemented
	Honduras	Fully implemented
	Mexico	Not fully implemented
	Paraguay	Not fully implemented
	Peru	Not fully implemented
	US	Fully implemented
Africa' **(2)**	Ghana	Not fully implemented
	Tunisia	Fully implemented

* * *

Хавсралт - 2.

Органик хөдөө аж ахуйн эрх зүйн зохицуулалт бий болгохоор ажиллаж байгаа орнуудын жагсаалт

Countries with regulations in development

Region	**Country**
'Europe' **(3)**	Bosnia Herzegovina
	Russia
	Ukraine
'Asia' **and Pacific Region (8)**	Armenia
	Azerbaijan
	Georgia
	Hong Kong
	Indonesia
	Lebanon
	Saudi Arabia
	Vietnam
The Americas & Caribbean (3)	Cuba
	Nicaragua
	St. Lucia
'Africa' **(2)**	Cameroon
	Egypt
	Madagascar
	South Africa

Хавсралт-3

- Зарим улс орнуудын органик хөдөө аж ахуйн эрх зүйн баримт бичиг болон танилцуулгуудын файлын жагсаалт

ХАВСАРГАСАН PDF-ФАЙЛУУД

1. Basic Standards list. IFOAM /4 pages - www.ifoam.org/
2. The IFOAM Basic Standards for Organic Production and Processing. Version 2005 /136 pages - www.ifoam.org/
3. The Process of Certification. IFOAM./17 pages – www.ifoam.org/
4. An International Standard for Forest Garden Products (FGP). IFOAM. /53 pages - www.analog-forestrynetwork.org/
5. OFDC Organic Certification Standards. Organic Food Development and Certification Center. April 2009. /68 pages - www.ifoam.org/
6. The World of Organic Agriculture. (Statistics & Emerging Trends 2011) FiBL AND IFOAM /292 pages - www.ifoam.org, www.fibl.org/
7. The IFOAM STANDARD for ORGANIC PRODUCTION and PROCESSING Version 2010 – Draft version 0.1. Compilation of comments and responses from the IFOAM Standard Committee. Comments received during the consultation period February – March 2011. Responses prepared during the period April-August 2011. /125 pages - www.ifoam.org/
8. The World of Organic Agriculture: Regulations and Certification: Emerging Trends 2008. Presented at BioFach Congress 2008, Nuremberg, February 2008. /13 pages – www.fibl.org/
9. Organic production and labeling of organic products and repealing Regulation. (EEC) No 2092/91. Council Regulation (European Council) No 834/2007. June 2007. /23 pages - www.ifoam-eu.org/
10. Overview of the implementation of the EU organic regulatory system. Standards & regulations. /8 pages - www.ifoam-eu.org/
11. Organic production of agricultural products and indications referring thereto on agricultural products and foodstuffs. COUNCIL REGULATION (EEC) No 2092/91. of 24 June 1991 /95 pages – www.ifoam-eu.org/
12. Bio Suisse Standards for the production, processing and marketing of produce from organic farming. Edition of 1 January 2011. /58 pages - www.bio-suisse.ch/
13. IMO Organic Equivalence Standard for Operators in Non-EU countries. Vers1.2. 2010 /100 pages www.imo.ch/
14. The law concerning standardization proper labeling of agricultural and forestry products. Japan. 2006 /20 pages/
15. Organic Foods Production Act Backgrounder. US. /11 pages - www.ota.com/pp/legislation/
16. FEDERAL ORGANIC FOODS PRODUCTION ACT OF 1990. (7 U.S. Code including amendments as of January 1, 2004) /13 pages - www.sarep.ucdavis.edu/organic/complianceguide/
17. QUALITY CONTROL FOR PROCESSED FOODS. Report of the APO Seminar on Quality Control for Processed Food held in the Republic of China, 8-14 May 2002. /68 pages - www.cpc.org.tw/
18. ARGENCERT S.A. is a Certification Body offering independent third party certification. ARGENTINA. Version V1.09 /77 pages - www.argencert.com.ar/
19. The National standard for organic and bio-dynamic produce. Australia. Third edition. December 2002. /67 pages - www.analogforestrynetwork.org/
20. NASAA Organic Trader Standard. August 2005. Australia. /14 pages - www.nasaa.com.au/
21. Organic Standards for Agriculture Production. TanCert-Tanzania Organic Certification Association. Short Standards for Local Market. December 2003. /13 pages/
22. East African Organic Standard-Draft. With comments. September 15, 2006. /42 pages - www.beesfordevelopment.org/
23. EnCert Organic Standards. Africa. June 2007. /61 pages - www.encert.co.ke/
24. Food and Agricultural Import Regulations and Standards – Narrative. Israel. 2010. /33 pages -

http://gain.fas.usda.gov/recent gain publications/ /

25. Food and Agricultural Import Regulations and Standards – Narrative. Japan. 2009. /12 pages - http://gain.fas.usda.gov/recent gain publications/ /

26. Organic Agriculture in Turkey. Trade opportunities for organic fruit and vegetables. Applied Plant Research. 2008. /27 pages - www.ppo.wur.nl/